



“1000 ЦҮНХ” АЯНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Хандивын зорилго:

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос нийгмийн хариуцлагынхаа хүрээнд “1000 ЦҮНХ” аяныг 2 дахь жилдээ зохион байгуулахаар бэлтгэл ажилдаа ороод байна.

- Эдийн засгийн энэ хүндрэлтэй үед ядуу бага орлоготой 1000 өрхийн төсөвт дэмжлэг үзүүлэх, хүүхдүүдийн сурч боловсрох, эрдэм боловсрол эзэмших чин хүслийг төрүүлэх, урам зоригыг нэмэх зорилгоор нэн ядуу, олон ам бүлтэй өрхийн 6-12 насны 1000 хүүхдэд хичээлийн иж бүрэн хэрэгсэл бүхий шинэ цүнхийг хандивлах
- Нийгмийн сайн сайхны төлөө хүмүүсийг нэгтгэн, эерэг санал санаачлагыг гаргаж, нийгэмд эерэг ойлголтыг бий болгох
- 1000 ЦҮНХ аяны хаалтын ажиллагааны үеэр ББСБ-уудын нэгдсэн өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж, сурталчилан таниулах

2. Хандивын үйл явц:

№	Хандивын үйл явц	Хамрах хугацаа	Тайлбар
1	Хандив цуглуулах, санхүүжилтийг бүрдүүлэх	2017.08.01- 2017.08.10 <u>10 хоног</u>	Холбооны гишүүн ББСБ-ууд хандиваа МББСБХолбооны худалдаа хөгжлийн банкны төгрөгийн 499 213 229 тоот дансанд хийнэ. 1 хүүхдэд хандивлах цүнх болон хичээлийн хэрэгслийн үнэ 38,000 төгрөг байхаар тооцож хандивлана.
2	Хандивлах цүнх болон хичээлийн хэрэгслийг бэлтгэх	2017.08.10- 2017.08.15 <u>5 хоног</u>	Холбооноос нэгдсэн байдлаар дараах 4 төрөлд 1000 хүүхдийн хичээлийн хэрэгслийг бэлтгэнэ. 1. 1-2 анги эрэгтэй, эмэгтэй хүүхдийн цүнх, иж бүрэн хичээлийн хэрэгсэл 2. 3-5 анги эрэгтэй, эмэгтэй хүүхдийн цүнх, иж бүрэн хичээлийн хэрэгсэл * 1 хүүхдэд: Цүнх, финал, дэвтэр 30 ш, хавтас, номын тавиур, зургийн дэвтэр, өнгийн цаас, шугам, баллуур, балын харандаа, өнгийн харандаа, харандаа үзүүрлэгч, хайч, цавуу, үзгэн бал, үзгэн балын запас, фламастер, баримлын шавар зэрэг орно.

3	Хандив өгөх шаардлагатай 1000 хүүхдийг сонгож, хүүхэд бүрт ваучер тараах	2017.08.10-2017.08.15 <u>5 хоног</u>	<p>Ядуу, бага орлоготой, олон ам бүлтэй өрхийн, 6-10 насны хүүхдийг сонгож, хүүхэд бүрт цүнх хандивлах ваучерийг олгоно. /Хүртээмжтэй байдлыг бодож нэг өрхөөс 1 хүүхэд сонгоно/</p> <p>Зорилтот бүлгийн хүүхдийг дараах 2 зарчимаар сонгоно:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хэрвээ хандив өгч буй ББСБ хүсвэл хандивласан цүнхний тоогоор зорилтот бүлгийн хүүхдүүдээ сонгож, мэдээллийг Холбоонд ирүүлэх. 2. Эсвэл Холбооноос хийгдсэн зорилтот бүлгийн 1000 хүүхдээс сонгож, хандивлах. <p>* Сонгогдсон 1000 хүүхдийн бүртгэлийг Холбоо нэгтгэж, давхардалыг ариган, хүүхэд бүрт ваучер олгох бөгөөд хүүхдүүд “1000 ЦҮНХ” аяны хаалтын ажиллагаан дээр ваучер, төрсний гэрчилгээний хамтаар хүрэлцэн ирж, хичээлийн хэрэгсэл бүхий цүнхээ гардаж авна.</p>
4	Хандивын хаалтын ажиллагаа	2017.08.25-ны өдөр Сүхбаатарын талбай дээр <u>10.00-16.00 цагт</u>	<p>Хаалтын ажиллагаанд: Зорилтот бүлгийн 1000 хүүхэд, тэдгээрийн эцэг эх, хороо нийгмийн ажилтанууд болон хандивын хаалтын ажиллагаа & ББСБ-уудын нэгдсэн өдөрлөгийг үзэж сонирхохоор хүрэлцэн ирж буй иргэд оролцоно.</p> <p><u>Хаалтын ажиллагааны үеэр:</u></p> <ul style="list-style-type: none"> ✓ ББСБ-уудын нэгдсэн өдөрлөг ✓ Бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга, зээл олгох үйл ажиллагаа гэх мэт ✓ Тэмцээн уралдаан урлаг соёлын арга хэмжээ
5	Сургалчилгаа, идэвхижүүлэлт	2017.08.01-2017.08.25 <u>25 хоног</u>	<ol style="list-style-type: none"> 1. Фэйсбүүк, сайт, Тв ашиглан сурталчилгааг хийх 2. Олны танил хүнээр ББСБ-ууд болон аяныг сурталчилах 3. ТВ-үүдээр мэдээ явуулах

3. Хамтран ажиллагч байгууллагууд:

- Нийслэлийн засаг даргын тамгын газар
- Санхүүгийн зохицуулах хороо
- Дэмжигч, хандивлагч ББСБ-ууд
- Монголын сурагчдын холбоо
- Монголын телевизүүдийн холбоо
- Монголын сайтын холбоо

4. Хандивын хэлбэрүүд:

Хандивлах цүнхий тооноос хамаарч ББСБ-уудыг ангилах бөгөөд дараах боломжууд олгогдоно.

А. 100-с дээш цүнх хандивлаж буй ББСБ:

- ✓ 5*5 харьцаатай асарыг А бүсээс сонгох боломж. Тухайн асартаа өдөрлөгийн үеэр өөрийн ББСБ-ын сурталчилан таниулах, бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулах боломж
- ✓ Тухайн ББСБ-ыг аянд хэрхэн оролцож, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж буй талаар олны танил хүнээр танилцуулга хийлгэж, богино хэмжээний видео шторк хийлгэх боломж
- ✓ Хамтран ажиллаж буй телевиз, сайт, нэвтрүүлэг зэрэгт оролцох, яриа өгөх боломж /1000 ЦҮНХ аянд хэрхэн оролцож буй талаараа мэдээлэл өгөх, ББСБ-аа танилцуулах/
- ✓ Сошиалаар сурталчилан таниулах, 1000 ЦҮНХ аяны талаарх видеонд оролцох боломж
- ✓ Цүнх хандивлах зорилтот бүлгийн хүүхдийг өөрсдөө сонгох боломж
- ✓ Аннос, баннер болон видео зэрэг сурталчилгааны самбаруудад ББСБ-ын логог байршуулах боломж.

Б. 50-100 цүнх хандивлаж буй ББСБ:

- ✓ 5*5 харьцаатай асарыг авах боломж. Тухайн асартаа өдөрлөгийн үеэр өөрийн ББСБ-ын сурталчилан таниулах, бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулах боломж
- ✓ Сошиалаар сурталчилан таниулах, 1000 ЦҮНХ аяны талаарх видеонд оролцох боломж
- ✓ Цүнх хандивлах зорилтот бүлгийн хүүхдийг өөрсдөө сонгох боломж
- ✓ Аннос, баннер болон видео зэрэг сурталчилгааны самбаруудад ББСБ-ын логог байршуулах боломж.

В. 50 хүртлэх цүнх хандивлаж буй ББСБ:

- ✓ Сошиалаар сурталчилан таниулах, 1000 ЦҮНХ аяны талаарх видеонд оролцох боломж
- ✓ Цүнх хандивлах зорилтот бүлгийн хүүхдийг өөрсдөө сонгох боломж
- ✓ Аннос, баннер болон видео зэрэг сурталчилгааны самбаруудад ББСБ-ын логог байршуулах боломж.

5. Талбайн засалт

Талбайн тайз болон засалт дараах байдалтай байна.

